



## ХУВЦАС ЗАГВАРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ СУДАЛГАА

Энэхүү судалгаагаар дамжуулан хувцас загварын зах зээлд үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгч, харилцагчдадаа зориулан тухайн зах зээлийн багтаамж, хэрэглэгчийн сегмент зэрэг бизнест хэрэг болохуйц шийдвэр гаргалтад туслах мэдээллээр хангах, зах зээлийн байр сууриа нэмэгдүүлэхэд шаардлагатай анхан шатны тойм судалгааг танилцуулж, хамтдаа хөгжих, хамтран ажиллах боломжийг МИРИМ Консалтант бүрдүүлж байна.

Бид хувцас загварын зах зээлд ноос ноолууран бүтээгдэхүүний зах зээл, экспортын судалгаа, худалдаа үйлчилгээ эрхлэгч байгууллагын судалгаа болон импортоор орж ирэх хувцас загварын хэрэглэгчийн судалгаа зэргийг хийж байсан туршлагатай.

Уг судалгаа Үндэсний статистикийн Хорооноос жил бүр эрхлэн гаргадаг Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны 2016 оны анхдагч статистик тоон мэдээлэл дээр үндэслэв. Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа нь жил бүр хүн амын амьжиргааны түвшин, ядуурал, өрхийн орлого, зарлага болон бусад хүчин зүйлсийг тооцоход зориулсан Монгол Улсын хэмжээний түүвэр судалгаа юм. Уг судалгаа жилд дунджаар 16,000 орчим өрхөөс 42 хуудас 215 асуулга бүхий түүвэр судалгаа авдаг ба 2016 онд 16,488 өрхийг хамруулсан байна. Судалгаанаас тооцох статистик тоон мэдээллүүд нийт улсыг төлөөлөх чадвартай ба энэхүү анхдагч өгөгдлөөс бизнесийн байгууллагууд өөрийн бизнест ашигтай мэдээллийг гаргаж авах бүрэн боломжтой.

Тухайлбал, хувцас загварын зах зээлд үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгчдэд хэн, ямар бүтээгдэхүүнийг хэр үнээр худалдан авдаг тухай болон зах зээлийн багтаамж хэд вэ зэрэг мэдээллүүдийг тооцоолох боломжийг уг судалгаа олгодог юм.



## ТАНИЛЦУУЛГА

Дэлхий дахинаа хамгийн хүчтэй өрсөлдөөний салбар болох хувцас загварын зах зээл жилээс жилд улам өргөжин тэлсээр байна. Хувцас загварын зах зээл дэлхийд 3 триллион доллараар үнэлэгдэж, 100 хүн тутмын нэг нь уг зах зээлд ажиллаж байна.<sup>1</sup>

Хэрэглээний зах зээлийн эргэлтээр нэгдүгээр байранд БНХАУ, хоёрдугаарт Япон улс ордог. Харин брэнд бүтээгдэхүүний хэрэглээгээр Европын Холбоо, Япон улсууд эхний байранд бичигддэг байна. Манай улсын хувцас загварын зах зээлд жилд дунджаар 108 тэрбум төгрөгийн импортын бүтээгдэхүүн эргэлддэг ба сүүлийн 3 жилийн байдлаар (2015-2017 он) 5 хувийн өсөлттэй явж байна.

Дэлхий загварын чиг хандлага хурдацтай өөрчлөгдөж, түүнийг дагасан хувцас загварын сонголт арвин болж байна. Иймд жил ирэх тусам уг зах зээлд ашигтай ажиллах нь хэцүү болж, бизнес эрхлэгчээс их мэдрэмж, тэр дундаа оновчтой шийдвэр гаргалт их шаардах болжээ.

Бизнес эрхлэгчдийн дунд импортоор оруулж буй бүтээгдэхүүн бүр ашигтай борлуулагддаг уу? Мэдээж үгүй.

- Яагаад хувцас загварын зах зээлд зарим бизнес эрхлэгч ашигтай ажиллаж, зарим нь хаалгаа барьж, алдагдал хүлээнэ вэ?
- Яагаад зарим байгууллагын ашиг тодорхой нэг цэг дээр очоод өөрчлөгдөхгүй уддаг вэ?
- Бизнес эрхлэгчид хэрэглэгчдийн зан төлөв, хүсэл сонирхол, худалдан авах чадвар, үйлдлийг урьдчилан тодорхойлж чадаж байна уу?
- Одоогийн зах зээлд хэрэглэгчдэд ямар бүтээгдэхүүн хүргэх нь ашигтай вэ? зэрэг асуултын цаана хэд хэдэн зүйлс нуугддаг.

Үүний нэг бол хэрэглэгчийн сегментийг бодитой зөв тодорхойлсон судалгаа, дүн шинжилгээнд суурилсан шийдвэр гаргалт, бизнес төлөвлөлт байдаг. Иймд судалгаа, дүн шинжилгээнд үндэслэсэн зах зээлийн тойм мэдээллийг бид Танд хүргэж байна.

## БЭЛЭН ХУВЦАСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Нэг өрхийн сарын дундаж орлого 950,000<sup>2</sup> төгрөг байгаагаас 66 хувийг хүнсний бус бараа үйлчилгээ, худалдан авахад зарцуулдаг. Дэлхийн дундажтай харьцуулахад хүнсний бус бараа үйлчилгээ, худалдан авалтад орлогынхоо 4,6<sup>3</sup> хувийг илүү зориулдаг. Энэхүү зардлын ангиллыг авч үзвэл зарцуулалтаар эхний 5-д эмэгтэй, эрэгтэй, хүүхдийн хувцас тус тус 12, 10, 8 хувийг эзэлж байна.

<sup>1</sup> Фэйшн Юнайтед 2017 он (Fashion United)

<sup>2</sup> 2017 оны IV улирлын байдлаар

<sup>3</sup> <http://datatopics.worldbank.org/>

Зураг 1: Сүүлийн 12 сард өрхийн хүнсний бус зардал, хэрэглээнд буюу нийт худалдан авалтад эзлэх хувь, ӨНЭЗС судалгаа




Эх сурвалж Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа 2016 он

Хувцас загварын зах зээлд эмэгтэйчүүдийн худалдан авалтын давтамж болон худалдан авалтад зарцуулж буй мөнгөн дүн эрэгтэйчүүдийнхээс 1,2 дахин илүү байдаг онцлогтой.

Хэрэглэгчид жилд дунджаар **оймс, дотуур хувцас, гадуур өмд** зэрэг бүтээгдэхүүнийг хамгийн олон тоогоор худалдан авдаг бол өвлийн пальто, курткар хамгийн их мөнгөн дүн зарцуулдаг ажээ. Бизнес эрхлэгчид хувцас загварын зах зээлд эмэгтэй бэлэн хувцас худалдаалах нь оновчтой, зөв сонголт болно.

Иймд цаашид эмэгтэй бэлэн хувцас болон өвлийн гадуур бэлэн хувцасны зах зээлийг онцолж авч үзье.

Зураг 2: Бэлэн хувцасны худалдан авалтад зарцуулж буй нийт мөнгөн дүн, төрөл бүрээр



Эх сурвалж Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа 2016 он

## ЭМЭГТЭЙ БЭЛЭН ХУВЦАС

Сүүлийн 3 жилийн байдлаар (2015-2017 он) дэлхийн эмэгтэй бэлэн хувцасны зах зээлийн багтаамж 400 их наяд долларт хүрээд байгаа ба дунджаар жилийн 3 хувийн өсөлттэй нэмэгдэж байна. Монгол Улсын хэмжээнд жилд дунджаар **56 тэрбум** гаруй төгрөгийг зөвхөн эмэгтэй бэлэн хувцас, 40 тэрбум төгрөгийг эрэгтэй бэлэн хувцас, 12 гаруй тэрбум төгрөгийг хүүхдийн хувцас худалдан авахад зарцуулдаг. **Импортын хувцасны загвар зах зээлд жилд 108 гаруй тэрбум төгрөг эргэлддэг.**

Иймд бизнес эрхлэгчид эмэгтэй бэлэн хувцаснаас ямар бүтээгдэхүүн борлуулах нь ашигтай вэ? Ямар бүтээгдэхүүнийг хэрэглэгчид илүү таашаах вэ? Уг асуултад Зураг 3 бидэнд хариулна. Эмэгтэй бэлэн хувцасны нийт худалдан авалтын зардлын нэгдүгээрт 14 хувиар өвлийн пальто куртка, хоёрдугаарт 12 хувиар өмд, удаах байранд ноосон болон ноолууран цамц, дотуур хувцас, зуны өдөр тутмын болон гоёлын даашинз юбка нар тус тус эзэлжээ.

Зураг 3: Эмэгтэй бэлэн хувцасны худалдан авалтын хувь




Эх сурвалж Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа 2016 он

Иймд бизнес эрхлэгч та өвлийн улиралд өвлийн пальто куртка худалдаалж, зуны улиралд загварын өдөр тутмын болон ажил хэрэгч даашинз хэрэглэгчдэдээ санал болгох нь оновчтой. Харин дотуур хувцас бол маш эрэлттэй бүтээгдэхүүн бөгөөд эрэгтэй хүнтэй харьцуулахад дотуур хувцсанд **2 дахин** илүү мөнгө зарцуулдаг. Эмэгтэй бэлэн хувцасны нэг удаагийн худалдан авалтад дунджаар **55,500** төгрөг зарцуулдаг ба энэ нь хүүхдийн хувцасны нэг удаагийн худалдан авалтад гаргаж буй зардлаас **2,2 дахин** их байна.

## ӨВЛИЙН ПАЛЬТО КУРТКАНЫ ЗАХ ЗЭЭЛ

Өвлийн пальто, курткод нийт өрхийн 40% нь **60,000₮ - 120,000₮** зарцуулдаг ба нийт өрхийн зөвхөн 1% л өвлийн гадуур хувцсанд 700,000 дээш төгрөгний худалдан авалт хийдэг. Үүнээс үзэхэд нийт өрхийн **98%** нь өвлийн пальто курткод **400,000**-аас доош төгрөгийг зарцуулдаг байна.

Зураг 4: Өвлийн куртканы худалдан авалтанд зарцуулж буй мөнгөн дүн



Эх сурвалж Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа 2016 он

Өрхийн гишүүдийн зарцуулалтыг тус бүрд ангилж авч үзье.

Эрэгтэй	Хүүхдийн	Эмэгтэй
Эрэгтэй өвлийн куртка, пальтоны нэг удаагийн худалдан авалтад дунджаар <b>118,095</b> төгрөг зарцуулдаг.	Хүүхдийн өвлийн куртка, пальтоны нэг удаагийн худалдан авалтад дунджаар <b>68,384</b> төгрөг зарцуулдаг.	Эмэгтэй өвлийн куртка, пальтоны нэг удаагийн худалдан авалтад дунджаар <b>132,272</b> төгрөг зарцуулдаг.



Өвлийн пальто куртканы дундаж зарцуулалтыг өрхийн орлого ба өрхийн гишүүдээр ангилж үзвэл:

Өрхийн сарын орлого	Өрхийн сарын орлого	Өрхийн сарын орлого
400,000төгрөгөөс бага	400,000 - 1,500,000төгрөг	1,500,000төгрөгөөс их
80,513 ₮	107,413 ₮	179,247 ₮
86,650 ₮	123,250 ₮	195,713 ₮
52,714 ₮	65,311 ₮	92,265 ₮

Сарын 1,500,000₮-өөс дээш орлоготой өрхүүд эмэгтэй өвлийн курткадаа дунджаар 195,713₮ зарцуулдаг бол сарын 400,000₮-өөс бага орлоготой өрх дунджаар 86,650₮ зарцуулдаг байна. Харин эрэгтэй бэлэн хувцасны хувьд 400,000-1,500,000₮ орлоготой өрх дунджаар 107,413₮ өвлийн курткадаа зарцуулдаг ба хүүхдийн өвлийн куртканы хувьд нэг өрх дунджаар 68,384₮ зарцуулдаг тул бизнес эрхлэгч та хэрэглэгчийн сегмент болон борлуулах үнийг оновчтой тодорхойлох нь таны бизнесийг өргөжүүлэх анхны алхам болно.